



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 1561

Улаанбаатар хот

“Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч”
аж ахуй нэгж шалгаруулах журам
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт арга технологи, сайн туршлага нэвтрүүлэн байгаль орчны нөхөн сэргээлтийг үр дүнтэй гүйцэтгэж буй хариуцлагатай “Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч” аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч аж ахуй нэгж байгууллага шалгаруулах хүсэлтийг хүлээн авч шалгаруулах ажлыг жил бүр үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар (Б.Буяаннэмэх)-т даалгасугай.

Б.Ба



Б.БАТ-ЭРДЭНЭ

153311621

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2023 оны 10 дүгээр сарын 10 өдрийн
2361 дугаар тушаалын хавсралт

“БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭРГҮҮНИЙ НӨХӨН СЭРГЭЭГЧ” АЖ АХУЙН
НЭГЖ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх, уул уурхайн олборлох, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх дэвшилтэт арга технологи, сайн туршлага нэвтрүүлсэн хариуцлагатай аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, шинэ санал санаачилгыг урамшуулан дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Шилдэг аж ахуйн нэгжийн шалгаруулалтад Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх, уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.

1.3. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан ажлын хэсэг удирдан зохион байгуулж, холбогдох саналыг сайдад танилцуулан шийдвэр гаргуулна.

1.4. Тэргүүний аж ахуйн нэгжийг шалгаруулах ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын дарга ахалж ажиллана.

1.5. Болзол хангасан аж ахуй нэгжүүдээс “Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч” 10 хүртэлх аж ахуй нэгжийг жил бүр шалгаруулж урамшуулна.

1.6. Шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах ажлын эхний шатны шалгаруулалтыг тухайн орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, холбогдох асуудал хариуцсан мэргэжилтнүүд орон нутагтаа зохион байгуулж санал дүгнэлтээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг, Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газарт ирүүлнэ.

Хоёр. Шалгаруулах үзүүлэлт

2.1. “Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч” байгууллага шалгаруулах болзол

2.1.1 Байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр даацад нь тохируулан холбогдох төлөвлөгөөний дагуу ашигладаг байх;

2.1.2 Байгаль орчныг хамгаалах хууль, дүрэм, журам, стандартыг тогтмол мөрдөж ажилладаг байх;

2.1.3 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төлөвлөдөг байх;

2.1.4 Үйлдвэрлэл, олборлолтын үйл ажиллагааны явцад тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэсэн байх;

2.1.5 Нөхөн сэргээлтийг холбогдох хууль дүрэм, стандартад нийцүүлэн чанартай сайн гүйцэтгэж холбогдох ажлын хэсэг, орон нутгийн байгууллагад хүлээлгэж өгдөг байх;

2.1.6 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд идэвх санаачилга гаргаж эвдэрч орхигдсон газарт нөхөн сэргээлт хийж холбогдох ажлын хэсэг, орон нутгийн байгууллагад хүлээлгэж өгдөг байх;

2.1.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90-ээс дээш оноотой дүгнэгдсэн байх;

2.1.8 Хог хаягдлыг багасгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ангилан ялгах, дахин ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байх;

2.1.9 Хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг ашигладаг байх;

2.1.10 Хаягдал усыг дахин ашиглах, борооны усыг хуримтлуулах технологи нэвтрүүлэх замаар усны нөөцийг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлсэн байх;

Гурав. Бүрдүүлж ирүүлэх материал, тавигдах шаардлага

3.1 Шалгаруулалтад оролцох байгууллага нь дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

3.1.1 Үйл ажиллагаандаа байгаль орчны хууль, тогтоомжийг чанд мөрдөж ажилладаг талаар орон нутгийн байгаль орчны мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, тодорхойлолт;

3.1.2 Журмын 2.1 дэх хэсэгт заасан шалгуур үзүүлэлт бүрээр гаргасан тайлан, нотлох баримт, мэдээлэл;

Дөрөв. Шалгаруулалт

4.1 Шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна.

4.1.1 Харьяалах аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь журмын 3 дугаар хэсэгт заасан “Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч” шалгаруулалтад оролцох аж ахуй нэгжийн материалыг 11 дүгээр сарын 15-ны дотор бүртгэн хүлээн авна.

4.1.2 Ирүүлсэн материалыг аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын тушаалаар байгуулагдсан 5-аас доошгүй гишүүнтэй ажлын хэсэг үнэлж шилдэг 3 хүртэлх аж ахуйн нэгжийн мэдээллийг ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийн хамт Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ.

4.1.3 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ирүүлсэн материалтай танилцаж шилдэг 10 хүртэлх аж ахуй нэгжийг шалгаруулна.

Тав. Шагнал, урамшуулал

5.1 “Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч” байгууллагаар шалгарсан 10 хүртэлх аж ахуй нэгж байгууллагуудын хэрэгжүүлсэн арга хэмжээ, сайн туршлагыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын гарын үсэг бүхий батламж мөнгөн шагнал гардуулна.

5.2 “Байгаль орчны тэргүүний нөхөн сэргээгч” байгууллагаар шалгаруулж, урамшуулах зардлыг жил бүрийн төсөвт суулгаж санхүүжүүлнэ.

--oOo--